Татварын бус орлогод төсөвт байгууллагын туслах үйл ажиллагаанаас 13.2 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 3,794.1 сая төгрөгийн орлого, зээлийн хүүгийн орлого 57.9 сая төгрөг байна. Үүнд: Өндөрхаан тохижилтын газрын үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 2,696.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

3.5.8 Зардлын данс

Үйл ажиллагааны нийт зардал 18,242.3 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардал 625.8 сая төгрөг байна. Үйл ажиллагааны бус зардал нь үндсэн хөрөнгийг данснаас хассантай холбоотой бөгөөд ОНХС-аас 590.0 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгийн зардал гарсан нь голлон нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 08 дугаар сарын 25-ны 01 дүгээр тогтоолд зааснаар төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 1,353.9 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,810.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 456.6 сая төгрөгөөр буюу 133.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

№	Орлогын нэр төрөл	2021 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	173.5	91.9	(81.6)	52.9
2	Хөрөнгө борлуулсны орлого	70.0	165.5	95.5	236.4
3	Хөрөнгийн орлого	420.0	562.1	142.1	133.8
4	Бууны албан татвар	4.4	5.4	1.0	122.1
5	Улсын тэмдэгтийн хураамж	10.2	7.4	(2.8)	72.6
6	Түгээмэл тархацтай АМНАТ	52.0	12.1	(39.9)	23.3
7	Хог хаягдлын хураамж	250.4	221.0	(29.4)	88.3
8	Агнуурын нөөц ашигласны төлбөр	0.4	38.2	37.8	955
9	Газрын төлбөр	24.0	21.8	(2.2)	90.6
10	Усны төлбөр	-	3.3	3.3	

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

11	Татварын торгууль	309.0	475.1	166.1	153.7
12	Бусад нэр заагдаагүй орлого	40.0	85.1	45.1	212.7
13	Малын хөлийн албан татвар	-	121.7	121.7	
Нийт дүн		1,353.9	1,810.6	456.6	133.7

Сумын төсвийн орлогын биелэлтийг орлогын төрлөөр авч үзвэл хөрөнгө борлуулсны орлого 95.5 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 142.2 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 37.8 сая төгрөгөөр, торгуулийн орлого 166.1 сая төгрөгөөр, бусад нэр заагдаагүй орлого 45.1 сая төгрөгөөр, малын хөлийн албан татвар 121.7 сая төгрөгөөр давсан байна.

Орлогын төлөвлөгөө давж биелэхэд тайлант онд төлөвлөгдөөгүй шонхор шувуу тусгай зөвшөөрлөөр бариулсны төлбөрийн орлого орсон, малын хөлийн албан татвар 2021 онд шинээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Үйл ажиллагааны орлого 81.6 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 2.8 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай АМНАТ 39.9 сая төгрөгөөр, хог хаягдлын хураамжийн орлого 29.3 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 2.2 сая төгрөгөөр, нийт 155.9 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1. “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;” заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-аас нийт зардал, эх үүсвэрийг 17,819.7 сая төгрөгөөр, тодотголоор 414.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт 18,234.5 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 18,234.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 16, сая төгрөгийг урсгал зардалд, 819.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлд 806.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 1740.7 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 1740.7 сая төгрөгөөр олгожээ.

Нийт зардлын 12,576.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 3,651.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,071.1 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангаас, 7,532.7 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 721.1 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 172.4 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

- Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 12,576.0 сая төгрөгийг олгосноос, сумын хурлын тогтоолоор баталсан дүнгээс Хэрлэн 1-р сургуульд ЕБС-д 34.5 сая төгрөгөөр, дутуу олгожээ.
- Орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт, орон нутгийн хөгжлийн сангаас олгох санхүүжилтийг бүрэн олгожээ.
- Эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтийг 1.6 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

- Үндсэн үйл ажиллагааны орлогод 508.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 210.0 сая төгрөгөөр тасарсан нь Жижиг дунд бизнесийг дэмжих сангийн батлагдсан орлогын төлөвлөгөөг 214.6 сая төгрөгөөр дутуу биелүүлснээс шалтгаалжээ.
- Туслах үйл ажиллагааны орлого 13.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 10.2 сая төгрөгөөр давсан нь Байгаль хамгаалах сан 2.1 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд сангийн хөрөнгөөр хийгдсэн хашааг зарсны үнэ 9.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 16,710.0 сая төгрөг буюу 91.8 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардал 868.7 сая төгрөг, хөрөнгийн зардал 83.6 сая төгрөг, эргэж төлөгдөх зээл 482.7 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардал 55.0 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна. Үүнд:

Урсгал зардлын гүйцэтгэлийг авч үзвэл цалин хөлс болон нэмэгдэл урамшил 195.7 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 120.4 сая төгрөгөөр, байр ашиглалтын тогтмол зардал 131.1 сая төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардал 4.1 сая төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 291.2 сая төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 4.9 сая төгрөгөөр, албан томилолтын зардлыг 2.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 105.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 12.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар 665.3 сая төгрөгийн 9 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 9.5 сая төгрөгийн 6-р цэцэрлэгийн баруун талыг тохижуулах, цэцэрлэгжүүлэх, аюулгүй бүс бий болгох, 50.0 сая төгрөгийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын 2 ажил хийгдээгүй, бусад 7 ажлыг 590.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.

Эргэж төлөгдөх зээл 482.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Жижиг дунд бизнесийг дэмжих сангаас олгох 260.0 сая төгрөгийн, Сум хөгжүүлэх сангаас олгох 222.9 сая төгрөгийн зээлийг олгоогүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

1. Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад батлагдсан төсвийн хүрээнд тэвчиж болох зардлыг хэмнээгүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан 116.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- Сумын ИТХ	4.9 сая төгрөг
- ЗДТГ	28.9 сая төгрөг
- ЕБ-ын 1-р сургууль	27.1 сая төгрөг
- ЕБ-ын 2-р сургууль	10.0 сая төгрөг
- ЕБ-ын 3-р сургууль	4.7 сая төгрөг
- ЕБ-ын 4-р сургууль	23.5 сая төгрөг
- 5-р Цэцэрлэг	4.1 сая төгрөг
- 8-р Цэцэрлэг	4.9 сая төгрөг
- 9-р Цэцэрлэг	7.2 сая төгрөг
- Тахилгат ЗАА	0.9 сая төгрөг

2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, эдийн засгийн ангилал зөрчин зарцуулсан 72.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- ЕБ-ын 1-р сургууль	1.3 сая төгрөг
- ЕБ-ын 2-р сургууль	11.2 сая төгрөг
- ЕБ-ын 4-р сургууль	0.8 сая төгрөг

- 7-р Цэцэрлэг	21.4 сая төгрөг
- 9-р Цэцэрлэг	18.6 сая төгрөг
- Хүүхдийн Ясли	1.8 сая төгрөг
- ЖДБДСан	4.5 сая төгрөг
- СХСан	10.5 сая төгрөг
- ОНХС	2.0 сая төгрөг

3. Батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан 42.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- ЕБ-ын 2-р сургууль	24.5 сая төгрөг
- ЕБ-ын 4-р сургууль	18.4 сая төгрөг

4. Өндөрхаан тохижилтын газар батлагдсан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 52.3 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлээгүй зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоосон.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,230.0 мянган төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 223,313.8 мянган төгрөгийн хөрөнгө, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 167,031.5 мянган төгрөгийн, нийт 391,575.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнд:

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 21,703.8 мянган, Засаг даргын тамгын газар 133,600.5 мянган, 1-р сургууль 53,429.9 мянган, 1-р цэцэрлэг 756.7 мянган, 2-р цэцэрлэг 757.3 мянган, 3-р цэцэрлэг 762.8 мянган, 4-р сургууль 14,579.7 мянган, 4-р цэцэрлэг 1,191.8 мянган, 5-р цэцэрлэг 1,801.0 мянган, 6-р цэцэрлэг 686.1 мянган, 7-р цэцэрлэг 1,135.3 мянган, 8-р цэцэрлэг 747.0 мянган, Соёлын төв 1,743.6 мянган, Тахилгат Захирагчийн ажлын алба 980.6 мянган, Тахилгат Эрүүл мэндийн төв 42,122.2 мянган, Тэмүүжин цогцолбор сургууль 48,003.8 мянган, Хан Хэнтий цогцолбор сургууль 39,299.8 мянган, Хүүхдийн ясли 569.0 мянган, Хот тохижилтын газар 25,691.9 мянган, 10-р цэцэрлэг 698.5 мянган, 9-р цэцэрлэг 1,314.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Үүнээс цалин хөлсний зардалд 3,000.0 мянган төгрөг, хангамжийн бараа материал худалдан авахад 47,385.7 мянган төгрөгийг, эм бэлдмэл нормативт зардалд 14,757.6 мянган төгрөгийг, эд хогшил, урсгал засварын зардалд 37,665.6 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 55,968.1 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 37,888.6 мянган төгрөгийг, төрөөс иргэдэд олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 61,578.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 11,550.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 2,237.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг ХЭА-2022/17/СТА-ТТЗ

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагч шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 636,858.0 мянган төгрөгийн 162 мэдээллийг 100 хувь мэдээлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,360.9 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх, Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж ажиллах зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- Сумын ИТХ	67.1 сая төгрөг
- Сумын ЗДТГ	588.9 сая төгрөг
- Соёлын төв	122.3 сая төгрөг
- ЕБ-ын 1-р сургууль	199.7 сая төгрөг
- ЕБ-ын 2-р сургууль	56.2 сая төгрөг
- Тахилгат Захирагчийн ажлын алба	10.0 сая төгрөг
- Тахилгат Эрүүл мэндийн төв	30.1 сая төгрөг
- Өндөрхаан тохижилтын газар	286.6 сая төгрөг

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага хүргүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагчид 19.0 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	141.0	1	141.0			100
Зөвлөмж	2	662.9	2	662.9			0
Нийт	3	803.9	3	803.9			100

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 21 төсвийн байгууллага, 1 төрийн сангийн, 2 хувийн цэцэрлэг, 4 тусгайн сангийн нийт 28 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 21 төсвийн байгууллага, 1 төрийн санд аудит хийж, Орон нутгийн хөгжлийн сан, Жижиг дунд бизнесийг дэмжих сан, Байгаль хамгаалах сан, Сум хөгжүүлэх сангууд аудитын түүвэрт хамрагдаж, 2 хувийн цэцэрлэг аудитад хамрагдаагүй болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Хэрлэн сумын 1-10 дугаар Цэцэрлэг, Хүүхдийн яслийн санхүүгийн тайланд "Өндөрхаан итгэл аудит" ХХК аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитад хамрагдсан харьяа 21 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 7-р Цэцэрлэг, 9-р Цэцэрлэг, 4-р Сургууль, Өндөрхаан тохижилтын газарт “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,005.4 сая төгрөгийн 57 алдаа, зөрчил илрүүлснээс 78.0 сая төгрөгийн 9 алдааг санхүүгийн тайланд залруулж, 58.0 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 1,707.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 27 албан шаардлага хүргүүлж, 161.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 14 зөвлөмжийг хүргүүлсэн.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүгүй нэгтгэсэн байна. Харьяа байгууллагын үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг нэгтгэхдээ төсөвт байгууллагуудад олгосон урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн 3,773.5 сая төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 185,3 сая төгрөг, нийт 3,958.8 сая төгрөгийг устгах бичилтийг хийж тайланг нэгтгэсэн байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Хэрлэн сумын ОНХС-ийн хөрөнгөөс иргэн Будсүрэн (ХААН банк 5954193104)-д хашааны төлбөрийг буцаан олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 5 сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2. “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Хэрлэн сумын ОНХС-ийн хөрөнгөөс Захиалагчийн хяналтын зардлыг олгохдоо хөдөө орон нутагт ажилласан томилолтыг үндэслэн олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2019 оны 12 сарын 25-ны өдрийн 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 10.7.11. “Зураг төсөл боловсруулах гэрээ, зохиогчийн хяналт, захиалагчийн хяналтын тухайн төсөл дээр байгуулсан гэрээний хуулбар, хийсэн ажлын тайлан” -г үндэслэн санхүүжүүлнэ гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Сум хөгжүүлэх сангаас 10,513.3 мянган төгрөгийг цалинд олгож зориулалт бусаар зарцуулсан нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.8-д заалт, Хэрлэн сумын жижиг дунд бизнесийг дэмжих сангийн журамд нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Төвлөрүүлсэн захирагчид 160.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 176.1 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлснээс 15.7 сая төгрөгийн 3 зөрчлийг дахин давтахгүй байх 3 албан шаардлага хүргүүлж, 160.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитад ирүүлэхдээ Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан заавар журмын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулгыг бүрэн бэлтгэн ирүүлсэн эсэхийг авч үзнэ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Үйл ажиллагааны орлого 81.6 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 2.8 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай АМНАТ 39.9 сая төгрөгөөр, хог хаягдлын хураамжийн орлого 29.3 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 2.2 сая төгрөгөөр, нийт 155.9 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2. Эрсдэл: Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлээгүй байх.

3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41.2.1 дэх заалтын дагуу төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлж ажиллах.

4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Жижиг дунд бизнесийг дэмжих сангаас 4,529.2 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Хэрлэн сумын жижиг дунд бизнесийг дэмжих сангийн журамд нийцэхгүй байна.

2. Эрсдэл: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байх

3. Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-ын 2014 оны 26 дугаар тогтоолоор баталсан "Хэрлэн сумын жижиг дунд бизнесийг дэмжих сангийн журам"-ийн 3.7-д заасан зардлаас өөр зардал гаргахгүй байх.

4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2022.04.10			ХЭА-2022/17/СТА-ТТЗ

ХЭА-2022/17/СТА-ТТЗ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шалгагдсан байгууллагын нэр:

Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч

сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Батлагдсан төсвийн хүрээнд тэвчиж болох 4.9 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.	4.8	Албан шаардлага өгсөн	ИТХ-ын нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	З.Энхболд О.Санжид
2	Тайлант онд нийт мэдээлбэл зохих 270.9 сая төгрөгийн 76 мэдээллээс 48.6 сая төгрөгийн 25 мэдээллийг мэдээлж, 222.3 сая төгрөгийн 51 мэдээллийг мэдээлээгүй.	222.3	Албан шаардлага өгсөн	ИТХ-ын нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	З.Энхболд О.Санжид
ИТХ-ын зөрчлийн дүн		227.1			
1	Батлагдсан төсвийн хүрээнд тэвчиж болох 26.7 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.	26.7	Албан шаардлага өгсөн	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Наранбат Д.Баярмаа
2	Шилэн дансны нийт мэдээлбэл зохих 2,239.4 сая төгрөгийн 236 мэдээллээс 1,650.6 сая мянган төгрөгийн 219 мэдээллийг мэдээлж, 588.9 сая төгрөгийн 29 мэдээллийг мэдээлээгүй байна.	588.9	Албан шаардлага өгсөн	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Наранбат Д.Баярмаа
3	Орон сууцанд амьдардаг ажилтнуудад 2.2 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгож, батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.	2.2	Албан шаардлага өгсөн	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Наранбат Д.Баярмаа
4	Багийн ахлагч нарт олгох урамшууллыг байгуулсан гэрээнээс 0.6 сая төгрөгөөр илүү олгосныг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо	0.6	Төлбөрийн акт тогтоосон	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Наранбат Д.Баярмаа
ЗДТГ-ын зөрчлийн дүн		618.4			

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	Шилэн дансанд мэдээлбэл зохих цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 122.3 сая төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй, мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх гэсэн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	122.3	Албан шаардлага өгсөн	Соёлын төвийн эрхлэгч, нягтлан бодогч	Д.Ганчөдөр О.Санжид
2	Бараа материалын үлдэгдэлд байх ёстой 1.5 сая төгрөгийн хөрөнгийг шууд зарлагадсан.	1.5	Санхүүгийн тайланд залруулсан	Нягтлан бодогч	О.Санжид
Соёлын төвийн зөрчлийн дүн		123.8			
1	Бараа материалын орлого, зарлага 0.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	0.4	Санхүүгийн тайланд залруулсан	Хэрлэн 1-р сургуулийн Нягтлан бодогч	Ц.Буянтогтох
2	Аудитын түүвэр тооллогоор бараа материалын үлдэгдэл 0.5 сая төгрөгөөр дутагдсан.	0.5	Төлбөрийн акт тогтоосон	Хэрлэн 1-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	Х.Алтанцэцэг Ц.Буянтогтох
3	Дотуур байрны хүүхдийн хоолны нормыг 1.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн.	1.4	Төлбөрийн акт тогтоосон	Хэрлэн 1-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	Х.Алтанцэцэг Ц.Буянтогтох
4	Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин урсгал засварын зардлаас 1.3 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авсан	1.3	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 1-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	Х.Алтанцэцэг Ц.Буянтогтох
5	Шилэн дансны нэгдсэн системд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад зарлагын мөнгөн гүйлгээг 199.7 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн.	199.7	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 1-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	Х.Алтанцэцэг Ц.Буянтогтох
6	Батлагдсан төсвийг 10 хүртэл хувиар хэмнээгүй, тавилга эд хогшил худалдан авч 27.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн.	27.1	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 1-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	Х.Алтанцэцэг Ц.Буянтогтох
Хэрлэн 1-р сургуулийн зөрчлийн дүн		230.4			
1	Бараа материалын дэлгэрэнгүй тайлангаар орлого, зарлага 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй.	0.2	Санхүүгийн тайланд залруулсан	Хэрлэн 2-р сургуулийн Нягтлан бодогч	Д.Эрдэнэтуяа

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	Сургуулийн өргөтгөлийн барилгын зураг төсөвт шилжүүлсэн 9.5 сая төгрөгийг зардалд бүртгэсэн.	9.5	Санхүүгийн тайланд залруулсан	Хэрлэн 2-р сургуулийн Нягтлан бодогч	Д.Эрдэнэтуяа
3	Ээлжийн амралтын хоногийн тооцоо хийгээгүйгээс 2.2 сая төгрөгийн цалин давхардуулан олгосон.	2.2	Төлбөрийн акт тогтоосон	Хэрлэн 2-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	К.Түмэндэлгэр Д.Эрдэнэтуяа
4	Батлагдсан төсвөөс үндэслэлгүйгээр 24.5 сая төгрөгийн тэтгэмж олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан.	24.5	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 2-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	К.Түмэндэлгэр Д.Эрдэнэтуяа
5	Батлагдсан төсвийн 10-аас доошгүй хувийг хэмнэх арга хэмжээ аваагүйгээс 6.3 сая төгрөг хэмнээгүй, 3.7 сая төгрөгөөр тавилга, ширээ сандал худалдан авсан	10.0	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 2-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	К.Түмэндэлгэр Д.Эрдэнэтуяа
6	Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин бага үнэтэй түргэн элэгдэх зүйлээс 11.2 сая төгрөгийн засварын материал, хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэсэн.	11.2	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 2-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	К.Түмэндэлгэр Д.Эрдэнэтуяа
7	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 56.2 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн системд мэдээлээгүй байна.	56.2	Зөвлөмж өгсөн	Хэрлэн 2-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	К.Түмэндэлгэр Д.Эрдэнэтуяа
Хэрлэн 2-р сургуулийн зөрчлийн дүн		113.8			
1	Дүрэмт хувцас бэлтгэхэд 4693.5 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.	4.7	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 3-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	М.Золзаяа Ц.Нарансолонго
Хэрлэн 3-р сургуулийн зөрчлийн дүн		4.7			
1	Бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 0.8 сая төгрөгийн урсгал засварын материал авсан.	0.8	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 4-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	Б.Жавхланбаяр Д.Саруултуяа
2	Ажилчдад 18.4 сая төгрөгийн урамшуулал олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.	18.4	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 4-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	Б.Жавхланбаяр Д.Саруултуяа
3	Албан конторын тавилга 23.5 сая төгрөгөөр худалдан авсан.	23.5	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 4-р сургуулийн Захирал Нягтлан бодогч	Б.Жавхланбаяр Д.Саруултуяа
Хэрлэн 4-р сургуулийн зөрчлийн дүн		42.7			

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	Тайлант онд нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 467.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.	0.5	Төлбөрийн акт тогтоосон	Хэрлэн 1-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	П.Болортунгалаг Д.Цэгмид
2	Е баримтгүй худалдан авалт хийж мөнгөн зарлага гаргасан.	4.1	Зөвлөмж өгсөн	Хэрлэн 1-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	П.Болортунгалаг Д.Цэгмид
	Хэрлэн 1-р Цэцэрлэгийн зөрчлийн дүн	4.6			
1	Е баримтгүй худалдан авалт хийж мөнгөн зарлага гаргасан.	6.0	Зөвлөмж өгсөн	Хэрлэн 2-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Ш.Оюунжаргал Д.Цэгмид
	Хэрлэн 2-р Цэцэрлэгийн зөрчлийн дүн	6.0			
1	Е баримтгүй худалдан авалт хийж мөнгөн зарлага гаргасан.	9.7	Зөвлөмж өгсөн	Хэрлэн 4-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Б.Энхтуяа Т.Төмөрболд
	Хэрлэн 4-р Цэцэрлэгийн зөрчлийн дүн	9.7			
1	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлын хэмнэлтээс ажиллагсад 4,139.4 мянган төгрөгийн шагнал урамшуулал, түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.	4.1	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 5-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	А.Ариунаа Н.Энхтуяа
2	Е баримтгүй худалдан авалт хийж мөнгөн зарлага гаргасан.	2.8	Зөвлөмж өгсөн	Хэрлэн 5-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	А.Ариунаа Н.Энхтуяа
	Хэрлэн 5-р Цэцэрлэгийн зөрчлийн дүн	6.9			
1	Байгууллагын ойг тохиолдуулан 75,000 төгрөгийн үнэтэй 25 ширхэг, 38,000 төгрөгийн үнэтэй 14 ш бичиг хэргийн ком, нийт 2.4 сая төгрөгийн эд материалыг бүх ажилчдад шаардах хуудсаар зарлагдаж бэлэглэсэн	2.4	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 6-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Б.Ариунаа Ж.Хулан
2	Е баримтгүй худалдан авалт хийж мөнгөн зарлага гаргасан.	0.2	Зөвлөмж өгсөн	Хэрлэн 6-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Б.Ариунаа Ж.Хулан
	Хэрлэн 6-р Цэцэрлэгийн зөрчлийн дүн	2.6			

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	Тайлант онд нийт 3,483 хүүхэд 8,6 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн зарцуулах нормтойгоос 9,1 сая төгрөгийн бүтээгдэхүүн зарцуулж, хоолны зардлыг 0,5 сая төгрөгөөр хэтрүүлсэн.	0.5	Төлбөрийн акт тогтоосон	Хэрлэн 7-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Г.Сансарцэцэг Ж.Хулан
2	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 14,4 сая төгрөгийн тавилга эд хогшил, БҮТЭЗ-ээс 7.0 сая төгрөгийн хивсэнцэр тус тус худалдан авч батлагдсан төсвийг ангилал зөрүүлэн зарцуулсан.	21.4	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 7-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Г.Сансарцэцэг Ж.Хулан
3	Е баримтгүй худалдан авалт хийж мөнгөн зарлага гаргасан.	0.1	Зөвлөмж өгсөн	Хэрлэн 7-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Г.Сансарцэцэг Ж.Хулан
Хэрлэн 7-р Цэцэрлэгийн зөрчлийн дүн		22.0			
1	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлын хэмнэлтээс ажиллагсдад 4,898.9 мянган төгрөгийн шагнал урамшуулал, түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.	4.9	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 8-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Нэргүй Н.Энхтуяа
2	Е баримтгүй худалдан авалт хийж мөнгөн зарлага гаргасан.	0.9	Зөвлөмж өгсөн	Хэрлэн 8-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Нэргүй Н.Энхтуяа
Хэрлэн 8-р Цэцэрлэгийн зөрчлийн дүн		5.8			
1	Бараа материалд 5,898.0 мянган төгрөгийн хивс, дрож, бутлагч бүртгэснийг залруулж үндсэн хөрөнгөнд бүртгэсэн.	5.9	Санхүүгийн тайланд залруулсан	Хэрлэн 9-р Цэцэрлэгийн Нягтлан бодогч	О.Отгонзул
2	Жилийн эцэст 40,242.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, тооцоо бодож баталгаажуулаагүй.	40.2	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 9-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Оюунгэрэл О.Отгонзул
3	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлын хэмнэлтээс 5,344.8 мянган төгрөгийн албан конторын тавилга, 1,823.5 мянган төгрөгийн ажлын хувцас худалдан авч нийт 7,168.3 мянган төгрөгийн зардал гаргасан.	7.2	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 9-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Оюунгэрэл О.Отгонзул

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Ажил олгогчоос төлөх 594,8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн зардлаас төлсөн, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас 18000.0 мянган төгрөгийн материал худалдан авсан. Нийт 18594.8 мянган төгрөгийн зардлын эдийн засгийн ангилал зөрүүлсэн.	18.6	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 9-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Оюунгэрэл О.Отгонзул
5	Хэрэгцээнээс илүүдэлтэй 31202.9 мянган төгрөгийн бичгийн цаас, даавуу, банз зэрэг материал бэлтгэсэн.	31.2	Албан шаардлага өгсөн	Хэрлэн 9-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Оюунгэрэл О.Отгонзул
6	Е баримтгүй худалдан авалт хийж мөнгөн зарлага гаргасан.	21.2	Зөвлөмж өгсөн	Хэрлэн 9-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Оюунгэрэл О.Отгонзул
Хэрлэн 9-р Цэцэрлэгийн зөрчлийн дүн		124.3			
1	Татвар, ҮЭ-ийн авлагыг буруу бичилт хийж хаасан байсныг илрүүлэн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.	2.0	Санхүүгийн тайланд залруулсан	Хэрлэн 10-р Цэцэрлэгийн Нягтлан бодогч	М.Цэнд-Аюуш
2	Е баримтгүй худалдан авалт хийж мөнгөн зарлага гаргасан.	20.3	Зөвлөмж өгсөн	Хэрлэн 10-р Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Б.Мөнгөнтуяа М.Цэнд-Аюуш
Хэрлэн 10-р Цэцэрлэгийн зөрчлийн дүн		22.3			
1	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 1,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 0,8 сая төгрөгийг цалингийн зардлаас төлсөн зэрэг нь батлагдсан төсвийг ангилал зөрүүлэн зарцуулсан байна.	1.8	Албан шаардлага өгсөн	Яслийн эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Золзаяа М.Цэнд-Аюуш
2	Е баримтгүй худалдан авалт хийж мөнгөн зарлага гаргасан.	0.1	Зөвлөмж өгсөн	Яслийн эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Золзаяа М.Цэнд-Аюуш
Хэрлэн Яслийн зөрчлийн дүн		1.9			
1	Барилгын засварын зураг, төсвийн урьдчилгааг зардалд бичсэн.	0.5	Санхүүгийн тайланд залруулсан	Нягтлан бодогч	Н.Батсайхан
2	батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 0.9 сая төгрөгийн тавилга авсан байна.	0.9	Албан шаардлага өгсөн	Захирагч Нягтлан бодогч	А.Ууганбаатар Н.Батсайхан

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	Тайлант онд шилэн дансанд мэдээлбэл зохих цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 133.0 сая төгрөгийн 12 гүйлгээг мэдээлэхээс 10.0 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.	10.0	Зөвлөмж өгсөн	Захирагч Нягтлан бодогч	А.Ууганбаатар Н.Батсайхан
Тахилгат ЗАА-ны зөрчлийн дүн		11.4			
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн 1 худалдан авалтын 5,225.0 мянган төгрөг, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн зарлагын 1 мөнгөн гүйлгээний 5,225.0 мянган төгрөг, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 12 шийдвэр 19,655.1 мянган төгрөгийг тус тус мэдээлээгүй зөрчил илэрсэн.	30.1	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч Нягтлан бодогч	Б.Эрдэнэцэцэг Н.Батсайхан
Тахилгат ЭМТ-ийн зөрчлийн дүн		30.1			
1	Дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй 10.0 сая төгрөгийн цэвэр усны байгууламжийг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлж бүртгэсэн.	10.0	Санхүүгийн тайланд залруулсан	Нягтлан бодогч	Т.Болортуяа
2	Тээврийн хэрэгсэл дансанд 48.0 сая төгрөгийн хогийн бункер бүртгэснийг бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн.	48.0	Санхүүгийн тайланд залруулсан	Нягтлан бодогч	Т.Болортуяа
3	Төсөвт зардлыг тохирсон эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаагүй. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас бүх зардлыг гаргасан байна	-	Зөвлөмж өгсөн	Захирал Нягтлан бодогч	О.Гомбобаатар Т.Болортуяа
4	Батлагдсан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 52.3 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлээгүй.	52.3	Төлбөрийн акт тогтоосон	Захирал Нягтлан бодогч	О.Гомбобаатар Т.Болортуяа

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	Шилэн дансанд мэдээлбэл зохих таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 286.6 сая төгрөгийн 24 гүйлгээг мэдээлээгүй, мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх гэсэн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна	286.6	Албан шаардлага өгсөн	Захирал Нягтлан бодогч	О.Гомбобаатар Т.Болортуяа
	Өндөрхаан тохижилтын газрын дүн	396.9			
1	Батлагдсан хөрөнгийг зориулалт бус зарцуулж, 4529.2 мянган төгрөгийн зардал гаргасан.	4.5	Зөвлөмж өгсөн	Хэрлэн сумын Засаг дарга	М.Шүрэнцэцэг О.Санжид
	ЖДБДС-ийн зөрчлийн дүн	4.5			
1	Батлагдсан хөрөнгийг зориулалт бус зарцуулж, 10513.3 мянган төгрөгийн цалин олгосон.	10.5	Албан шаардлага өгсөн	Хэрлэн сумын Засаг дарга	М.Шүрэнцэцэг О.Санжид
	СХС-ийн зөрчлийн дүн	10.5			
1	Батлагдсан хөрөнгийг зориулалт бус зарцуулсан	2.0	Албан шаардлага өгсөн	Хэрлэн сумын Засаг дарга	М.Шүрэнцэцэг О.Санжид
2	БИЗ-ын ажлын гүйцэтгэл баталгаажуулаагүй 3164.6 мянган төгрөгийг олгосон.	3.2	Албан шаардлага өгсөн	Хэрлэн сумын Засаг дарга	М.Шүрэнцэцэг О.Санжид
	ОНХС-ийн зөрчлийн дүн	5.2			
1	Үйл ажиллагааны орлого 81636.1 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 2799.6 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай АМНАТ 39896.9 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамжийн орлого 29359.9 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 2246.6 мянган төгрөгөөр, нийт 155939.1 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн	155.9	Зөвлөмж өгсөн	Хэрлэн сумын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	М.Шүрэнцэцэг Ж.Ундармаа
	ТТЗ-ийн дүн	155.9			
	Нийт дүн	2,181.5			